

- 36: “Эрдэнэ тунамал нэрт судар” т. 145
 37. "Болор эрхи" т.819 ӨМАХХ 1985
 38. "Мин улсын түүх" 327-р боть дэвтэр 28
 Жүнхуагийн номын товчоо 1974 т. 8467
 39. Мөн тэнд. 327-р боть. шаштирын 215

ИХ МОНГОЛ ГҮРЭН-ТҮҮНИЙ
 ГАДААД ХАРИЛЦАА

*М.Хурметхан**

Чингис хаан Инд мөрөн хүрсэн боловч өөрөө Энэтхэгт очоогүй юм. Харин Чингис хааны хан хөвгүүн Цагаадай 1221 - 1222 онд Хорезм шах Жалел ад-Динийг баривчлахаар Энэтхэгт очсон билээ. Чухамдаа тэр үеээс Энэтхэгт монгол хүн, монгол цэрэг харагдах болж удаа дараа халдан довтолж байв. Монголчууд Энэтхэгт улам дотночлон бүр Лахор хүрсэн төдийгүй зарим газар нутаглан сууж байв. Тэр үед Энэтхэгт Монгол хүн оршин сууж байсныг гэрчилэх сурвалж бичигт эд мөрийн баримт, хот тосгоны нэр гэх мэт зүйл хадгалагдан иржээ. Чингис хаанаас хойш 180-аад жил улиран өнгөрсний дараа Дундад Азийн цэргийн гарамгай жанжин, Эмир Төмөр Энэтхэг рүү довтлон 1398 онд Дели хотыг эзлэв. Төмөр буюу Доголон Төмөр хэмээн алдаршсан тэр хүн бол Хүлэгү хааны угсааных байсан юм. Ийнхүү Чингис хааны угсааныхан Энэтхэгт дахин хөл тавьжээ. Чингис хаанаас 300 жил, Доголон Төмөрөөс 130-аад жилийн дараа Чингис хааны угсааны цэргийн өөр нэг алдарт жанжин агуу их эр зоригтой, бичгийн их хүн Бабур Захир ад-Дин Мухаммед (1483-1530) нь Энэтхэг орных эзлэн, Их Могол (Монгол)-ын эзэнт гүрнийг үндэслэн байгуулж, Энэтхэг орны түүхэнд гайхамшигтай шинэ хуудасыг нээсэн юм. Бабур хаан бол эцгийн талаас Доголон Төмөрийн удмаас, эхийн талаас Цагаадын удмаас гаралтай юм. Тэрээр 12 наснаас Ферган мужийн захирагч болж улмаар Төмөрийн угсааныханы өөр хоорондын тэмцлийн улмаас Бабур нь 1504 онд Төв Азиас гарч явжээ. Улмаар олон тооны цэргийн хамт Кабулд хүрэлцэн очиж, тэндэхийн захирагч Ил хаан Аргуны хүү Зун-Кунбекиг ялж, 1506 онд өөрийгөө их хаан хэмээн зарлав. Бабурын армийн гол хүч нь Цагаадай, барлас, Жалайр, Афганы аймгийн цэргээс бүрдэж байв. Тэрээр Кабулд бэхжиж, улмаар 1518-19, 1524-25 онуудад Энэтхэг рүү 5 удаа аян дайнд мордож. 1526 онд Лахор, Пенджаб, Аграт эзлэн Умарт Энэтхэгт Их Моголын эзэнт гүрнийг үндэслэн байгуулж, удирдсан юм. Бабур “1526 онд Делийг эзэлснээр Энэтхэгийн шинэ эрин үе, монголчуудын шинэ эзэнт улсын үе эхэлжээ”⁽¹⁾ хэмээн Ж.Неру үнэлэн бичсэн байдаг юм. Бабур бол Чингис хаан, Төмөрийн угсааны хүн болохоор түүнд тэдний оюун ухаан, хүч чадал, цэргийн эрдэм, төрийн мэргэн ухаан, авъяас билиг уламжлагдан өвлөгдөж, шинэ цаг үе, шинэ улс оронд Чингис хааны угсааны хаанаас дахин нэг удаа, хүчирхэг эзэнт их гүрнийг байгуулах

*Түүхийн ухааны дэд доктор

их хувь заяа Бабурт ноогджээ. Бабур болон түүний угсааныхан Их Моголын (Энэтхэгийг 1526-1858 оны хооронд удирдан захирав. Бабур бол “бусдаасаа илүү соёлтой, хүнийг биедээ татах чадалтай ялдамхан хүн байжээ⁽²⁾ Өөрөөр хэлбэл, тэрээр Энэтхэгт эвдлэн сүйтгэх ажил явуулаагүй бөгөөд хөгжлийн илүү дээд шат руу хөтөлжээ. Бабурын арми тун цөөн хүнтэй боловч Европ, Өрнөд Азид хэрэгтэй эхэлсэн шинэ маягийн их буугаар зэвсэглэсэн байжээ. Тэрээр Кабулд байхдаа Европ, Өрнөд Азид ямар нэгэн хэмжээгээр харилцаа холбоо тогтоон зэр зэвсэг олж авсан нь тодорхой юм. Бабур болон түүний угсааныханы цэргийн стратеги, тактик нь Чингисийн үеийнхээс онцын ялгаагүй, зөвхөн зэр зэвсэг нь орчин үеийнх байсан хийгээд цэргийн тоо цөөхөн байжээ.

Бабур нь Энэтхэгт довтлохын өмнө өөрийн элчийг зарж, тэдгээрийн захирагчдад эсэргүүцэхгүй бууж өгөхийг шаарддаг байв. Тухайлбал, Делийн султан Ибрахим Лоднд тийм шаардлага тавьж, тэр үүнийг үл хэрэгссэн учир цэргийн хүчээр довтлон, афганчуудын тоо тоймшгүй их цэргийг цөөн хүчээр бут цохижээ. Бабур бол өөрийн үзэж өнгөрүүлсэн амьдрал, төрийн хэргийн талаар өөрийнхөө “Бабур наме”д тодорхой бичиж үлдээсэн ажээ.

Бабур Энэтхэгт Их моголын эзэнт гүрнийг байгуулан төрийн эрхийг дөрвөн жил барьжээ. Тэрээр энэ хүч асар богино хугацаанд өөрийнхээ суу билгийн хүчээр улс орныхоо дотоод, гадаад байдалд ихээхэн ажил хийж гүйцэтгэжээ. Учир нь түүхийн шинэ нөхцөлд өөртөө огт танил бус ард түмний дунд, өөрийн төрөлх ард түмэн, ахан дүүс, төрж өссөн Ферган нутгаас алс хол, байгаль, газар зүй, цаг уурын өөр нөхцөлд агуу их гүрнийг үндэслэн байгуулахад Чингисийн угсааны энэ хүнд ч хосгүй их ухаан, чадал шаардагдсан нь тодорхой. Тархай бутархай Энэтхэг орныг нэг төвд нэгтгэн, эдийн засаг, соёл, худалдаа хөгжүүлэх талаар их ажил хийж гүйцэтгэжээ. Тэр Аград сайхан нийслэл хот байгуулан, нэгэн алдарт уран барилгачинг авчруулахаар Константинополь руу элч илгээжээ. Бабурын энэ хүсэлтийг хүлээн авсан Оттаманы нэртэй уран барилгачин Синан гэдэг шавиа явуулжээ.⁽³⁾ Үүнээс үзэхэд Бабур нь урьдаас Константинопольтой холбоо харилцаатай болох нь харагдаж байна. Бабур Энэтхэгт Их могол гүрнийг байгуулан, төр барих болсны дараа Төв Ази дахь өөрийн ах дүү, хамаатан садан шайбаны удмынхантай харилцаа холбоо тогтоохыг эрмэлзэж байв. Нөгөө талаар Цагаадайн улсынхантай холбоо харилцаа тогтоохыг ч мартаагүй юм. Тухайлбал, Энэтхэг рүү байлдааны ажиллагааг үргэлжлүүлэнгээ, Кашгар руу элч илгээжээ. Тэрхүү Абд ал-Манук курчи хэмээх элч нь 7-8 сар өнгөрсний дараа. Султан Сайд хааны элч Янги бек Кукальташийн хамтаар хаан, хатан нарын захиа, бэлэг сэлтийг ч Бабурд хүргэн иржээ. 1929 онд түүнд Төв Азийн Куч-Күнчи хаанаас элч ирэв. Тэрчилэн Бабур хаан Орос оронд II Василий Ивановичид ах дүүгийн найрамдал болон худалдааны харилцаа тогтоохоор захиа бичиж, элч заржээ. Бабурын элч төлөөлөгчид 1532 онд Орост хүрэлцэн ирсэн байна. Бабур хаан 1530 оны 12-р сарын 26-нд Аград нас эцэслэж, Кабул хотод авч ирж оршуулсан байна.

Бабур нас барсны дараа хаан ширээг түүний хүү Хумайн Наср-ад Дин (1508-1556) өвлөн уламжлав. Тэрээр Энэтхэгт 1530-39. 1555-56 онуудад төрийн эрхийг барив. Хумайн эцгийнхээ байгуулсан эзэнт гүрнийг бэхжүүлэх, нутаг дэвсгэрийг нь өргөтгөх бодлого явуулж байв. Өөр хоорондын тэмцэлд 1539 онд Хумайн ялагдаж, хэсэг хугацаанд Баруун Энэтхэг, Афганистанд байгаад улмаар Иранд очив. Ираны эзэн хаан Тахмис нутагтаа орогнуулсан байна. Ираны цэргийн тусламжаар 1556 онд Пенджаб, Дели, Аград төрийн эрхийг дахин гартаа авчээ. Энэтхэгийг Хумайн хаан захирч байсан үеийн гадаад харилцааны асуудал нь гол нь Португалийнхан Энэтхэгт орж ирсэн явдалтай холбогдох юм. Португалийнхан Энэтхэгт анх 1498 онд далайгаар хүрэлцэн ирсэн байжээ. Улмаар 1510 онд тус улсын баруун талын усан боомт Гаог эзлэн авснаар португалийнханы колончиллын бодлогын шинэ эхлэл тавигдаж, Энэтхэгт бэхжиж амжсан байна. Өмнөд Энэтхэгийн жижиг улсуудыг эзлэн Энэтхэгийн баруун эргийн хамгийн том улс Гуджаратад аюул учруулж, гуджаратынхан ч зоригтой эсэргүүцэл үзүүлж байв. Их моголын эзэн хаан Хумайн 1535 онд Гуджаратыг эзлээд, Бахадур португалчуудаас тусламж гуйж, хэлэлцээр хийж, Диуг солилцон авахаар болжээ. Португалийнхан Энэтхэгийн нилээд газрыг тухайлбал, 1534 онд Бассени, 1546 онд Сальпетт, Вард зэргийг эзлэв.

1542 оны 1-р сард Хумайны эхнэрээс Акбар Жаалал ад-Дин төржээ. Тэрээр 1542-1605 оны хооронд амьдарч, их моголын эзэнт гүрний хаан ширээнд 1556-1605 оны хүртэл бараг 50 жил суужээ. Их Моголын эзэнт гүрний их хаан Акбар нь төр барьсан үедээ эзэнт гүрнийхээ газар нутгийг ихээхэн өргөтгөж, могол угсааны хүчин чадлыг бэхжүүлэн, олон тооны шинэтгэл хийж, Энэтхэг дахь моголын хаанчлалын үндсийг жинхэнэ тавьсан хүн ажээ.⁽⁴⁾ Эзэнт гүрнийг нэгтгэх талаар Акбар их хүчин чармайлт гаргасны ачаар түүний нас барснаас хойш Бабурын угсааны хаанчлал зуугаад жил үргэлжилэв. Акбар нь дайчин зоригтой, авъяаслаг цэргийн жанжин, торийн гарамгай зүтгэлтэн билээ. Акбарын ордныхон португалийн элч төлөөлөгчдийг асар их хүндэтгэн устаж, Акбар гол төлөв португаличуудаар дамжуулан европ дахинтай холбоо барьж байжээ. Тэр португалчуудыг далай дээр ноёрхсон европын хамгийн хүчирхэг үндэстэн гэж үзэж байжээ. Акбар Гоог эзлэн авах гэж довтолж үзсэн боловч амжилт олоогүй аж. Их Моголууд нь далайд хүч сул, тэнгисийн гүрнүүдийг үнэндээ яаж ч чаддаггүй байв. Их Моголын хаад хуурай газарт дайн байлдаан хийх талаар илүү байсан ажээ. Ер нь Чингис хааны угсааны хаад нь их далайд гарахыг оролдож байсан боловч Их могол. Юан улс (Хубилай) амжилт олоогүй юм. Учир нь моголууд нь эх газрын үндэстэн учир их далайн ааш занг сайн төсөөлөхгүй байв. Чухамдаа Их Моголын эзэнт гүрэн мөхсөний нэг шалтгаан нь энэ юм. Акбар хааны үед Энэтхэг дахь европынханы бааз нь жижиг байсан боловч далайн эрэг дагуу сайн хамгаалагдсан суурингууд байв. Тэд улс орны дотоод руу нэвтэрч чадахгүй байсан боловч Их Моголын эзэн хаадад өөрсдийнхээ элч төлөөлөгчдийг илгээж байв. Тэд нар Агра руу гурван удаагийн иезуитийн элч явуулснаас хоёр нь Акбарт, нэг нь Жахангирт ирж байжээ. “Бас түүнтэй ирж уулзаж байсан гадаадынхан, ялангуяа түүнийг загалмайтны шашинд оруулахыг хичээж байсан иезиутууд

түүний тухай их зүйл бичиж үлдээжээ”⁽⁵⁾ хэмээн Ж.Неру тэмдэглэжээ. Их Моголын эзэнт гүрний хаадыг шашиндаа оруулах христосуудын итгэл хүсэл нь биелэгдсэнгүй боловч Их Моголын ордонд незутуудынхан ихээхэн нөлөөтэй байв. Өөрсдийнхээ эзэмшил дээр португалийнхан энэтхэгчүүдийг христосын шашинд албадан оруулж. Индусын сүм хийдийг устган, шашин шүтлэгээ хамгаалах гэсэн хүн амын эсэргүүцлийг хүчээр дарж байв. 1557 оноос Гао нь епископ. 1559 оноос архиепископ хэмээн нэрлэгдэж өөрийн нөлөөгөө өргөжүүлж байв. Энэтхэгийн эрэгт бэхжсэн португалийн ханы гол орлого нь дорно дахинтай хийсэн худалдаанаас орж байв. Португалийнхан Бенгалид Хятад, Японы барга авч ирж, эндээс бөс даавуу, цагаан будаа, тутарга, шүү, лав, торгоны түүхий эд зөрдөг байв.⁽⁶⁾

Раджпут угсааны хатнаас гарсан хүү Жахангир нь Акбар хааныг залгамжлан Их Моголын дөрөв дахь Их хаан суув. Түүний нэр нь “ертөнцийн байлдаан дагуулагч” гэсэн перс үг юм. Түүнийг 1605-1627 оны хооронд 22 жил их хаан суух үед төв засаг сулран, орон нутгийн ноёдын захиргаа хүчирхэгжижээ. Тэрбээр мөн ихээхэн авъяаслаг хүн байсан боловч, улс орны дотоодод үүссэн сөрөг үзэгдэлийг бүрэн хараахан зохицуулж чадсангүй. Тэрээр 1613 онд Өмнөд Энэтхэг команд сурахад худалдаа хийхийг зөвшөөрөв. 1622 онд Ираныхан Кандагар хотыг эзлэв.

Жахангирийн дараа түүний хүү Шах Жахан (1627-58 онд Их Моголын эзэнт гүрний төрийг 30 жил барив. Түүний үед Энэтхэг дахь моголуудын хүчирхэг нь дээд цэгтээ хүрсэн хэдий ч уналтын анхны шинж тэмдэг гарч иржээ. Түүний үед Энэтхэгт уран барилга ихээхэн хөгжиж, Таж Махалыг бариулжээ. Голланд, англичууд том боомт хот Малака хүрч 1641 онд голландчуудын гарт оров. 1629 онд Хуглид Шах Жахан ба португалчуудын хооронд сүрхий мөргөлдөөн болжээ. Моголчууд баатарлаг хамгаалснаар Хуглийг гартаа оруулж амжсан байна. Дараа нь Аурангзеб нь Их Могол гүрний сүүлчийн 6 дахь их хаан байв. Тэрээр 1658-1707 онд 48 жил их хаан суужээ. Энэтхэгийн зүүн талын зарим мужийг нэгтгэсэн боловч, түүний цэрэг англичуудын Бомбейгээс хөөн гаргаж амжсангүй юм. Түүний хаан суух хугацааны төгсгөлд “олон муж улс” эзэнт гүрэн салж тасарсан байна. Их монголын эзэнт гүрэн задран унах урьдач нөхцөл, өөрөөр хэлбэл, дотоодын ялзрал, доройтол газар авчээ. Аурганзебийн дараа Бахадур цаг Жахандаршаг (1707-1712), Ферух Синтяр (1718-19), Мухаммед (1713-1719), II Шаг Адам (1759-1806), II Акбар (1806- 36), Бахардуршаг II (1837 - 58) хаан ширээ залгамжилжээ.

Аурганзебийн үед португалчууд байгалийн давсны дотоод худалдааг түрээстэн авсан нь орон нутгийн бүтээгдэхүүнийг худалдан авах хөрөнгө өгч байв. Гүн дэх мужуудтай холбоогүй учир тэд Энэтхэгийн худалдан авагчид бүрт найдаж байжээ. Португалчууд дорнын худалдаачдыг түүний дотор энэтхэгийнхний гартлаа бүрэн авч худалдаа наймаах нь хураахыг эрмэлзэж байв. Португалчуудын үйл ажиллагааг нь Алс Дорнод, Европт руу гарах Энэтхэгийн бараа борлуулалтын зах зээлийг өргөтгөсөн боловч энэтхэгийн худалдаачдад ашиг өгөхгүй байв.

Булаан эзлэгчдийн түшиц газрууд хоорондоо хол зайтай байсан учир далайд ноёлж байж л тэднийг айлгаж болох байв. Португалчуудад Их моголын хуурай замын арми тогтон барих хүч болж байсан боловч тэд зэвсгийн хүчний илүүгээр амархан няцааж. Тэр ч байтугай эзэмшлээ өргөтгөж байлаа. Гэвч XIV зууны эцсэр энэтхэгийн далайд англи болон голландын хөлгүүд бий болж, португалчуудын тэнгисийн зам харилцааг тасалж эхлэв. 1605 оноос португалийнхан дорно дахь эзэмшлээ алдаж эхэлсэн байна. 1630 онд португалчууд Малабарт англичууд худалдаа хийхийг зөвшөөрөн. 1632 онд Их Моголчууд тэдний Бенгалиас хөөн зайлуулав. 16002 онд Нидерланд (Голланд) дорно Энэтхэгийн компани байгуулав. Энэхүү компани нь Европын өрсөлдөгчдийн эсрэг цэрэг дайны ажиллагаа явуулах зардал болон колончилолтын булаан эзэмшлийг өргөтгөх зардал гаргаж байжээ. Энэтхэгт голландын худалдаа ид явагдаж байх үедээ (XVIII зууны 40-50-иад он) эрэг хавьд жилд гаргаж байсан барааны үнэ 1,5 саяаас 2.5 сая флорин болж байжээ. XVII зуунд Их Моголынхон голландын суурингуудыг эрхшээлдээ авахыг хичээж янз бүрийн арга хэрэглэж байжээ. Голандчууд Энэтхэгт гар урлал, худалдааг зохион байгуулах шинэ арга нэвтрүүлэхийг эрмэлзэж, янз бүрийн үйлдвэр байгуулж байсан боловч бүтээгдэхүүний чанар, зах зээл зэргээс болж, үйл ажиллагаа нь ихээхэн буурахад хүрчээ. Английн худалдаачид голландчуудаас хэдэн жилийн өмнө Сайн Итгэлтийн буланг (1592) тойрч Энэтхэгийн далайд дээрэм хийж эхэлжээ. 16000 онд Энэтхэг худалдаа хийх зориулалттай дорно зүгт онц эрх эдлэх худалдаа хийхийг хатан хаан Елизаветаас авсан байна. 1708 онд Дорно Энэтхэгийн компани Энэтхэгийн хэргээ жинхэнээр гүйцэтгэж чадах болов. Тэр үеийн тэнгисийн экспедицүүд нь англичуудад хөрөнгө оруулалтын орлогын 95 хүртэл хувийг оруулж байсан боловч Лондонд зарагдсан барааны ихэнх хэсэг нь зах зээл дээрээс биш тэнгист дээрэмдэгдсэн бараа байв. Тухайлбал, 1611 онд английн далайн экспедицийн дарга Мидлоон, гуджаратын 6 усан онгоцыг баривчилжээ. Цаашид англичууд нь Моголуудаас худалдаа хийх онц эрхийг авахын тулд нэг биш удаа хүч хэрэглэж байв.

1608 онд Энэтхэгийн эрэгт хүрсэн Компани анхны хөлгөөр Суратад У.Хоукинг ирж Агра дахь Их хаан Жахангиур руу явжээ. Португалчуудын явууллага У.Хоукинг үүргээ амжилттай биелүүлэхэд саад болж, гэр 1611 онд нийслэлээс явжээ.⁽⁷⁾ Гэвч 1612 онд англичууд португалийн флотийг Суратын орчим бут ниргэснээр их хаан Жахангир нь англичуудтай үл сөргөлдөхийг бодон Дорнод Энэтхэг компанид Суратад худалдааны компани нээхийг зөвшөөрсөн байна. Ингээд Сурат Их Могол гүрэн дахь Их Британи эзэмшлийн төв болов.

1615 онд Их Моголын нийслэл Аград Английн хаан I-ийн Иаков элчин сэр Томас Р. албан ёсоор хүрэлцэн иржээ. Тэрээр их Моголчуудын ордонд гурван жил сууж, англичууд Бенегалитай худалдаа хийх эрхийг олж авч чадсан байна. Их хаан Жахангирийг фирманууд итгэх бэрх байлаа. Хэрэв зохих бэлэг хахууль өгөхгүй бол Их моголын хаан амласнаасаа хэзээ ч буцаж болох байв. Гэхдээ энэ үеэс л могол гүрэнд английн худалдаа өргөжив. Английн худалдааны

үйл ажиллагаа явуулах гол төв нь Гуджарат байв. Тэндээс их могол гүрний дотоод мужуудад бараагаа оруулж байжээ. 60-аад оноос Сурат нь Их Моголын эзэнт гүрний худалдааны том төв болж бусад дорно зүгийн орнуудын гол зах зээл болов. 1623 онд англичуд Жахангир хаанаас Суратад жилд 3 хөлөг онгоц хийх зөвшөөрөл авч, дараагаар нь хөлөг онгоцны үйлдвэрийг байнга ашиглаж байжээ. Англичууд 1644 оноос бусад зарим үйлдвэрийн газар байгуулжээ. 1639 онд Дорнод Энэтхэгийн компани нь Мадрасын ойролцоо газар түрээслэн авч тэнд бэхлэлт барьжээ. XVIII зууны эхэнд энэ хот нь Британи Энэтхэг дахь засаг захиргааны том төв болж хувирав. Англичуудын хувьд Бомбейн арал хоёрдугаар зэргийн ач холбогдолтой байв. Их Моголын хаад Бомбейг эрхшээлдээ оруулахыг оролдож, түүний оршин суугчид энэтхэгчүүд болон европчуудаас джизи төлөхийг шаардаж байв. Хариуд нь Бомбейн амбан захирагч Джон Чайлд. 1628 онд Суратыг бүслэн хаажээ. Энэ үеэр Биджагурыг унасны дараа их моголуудад алба хаах болсон Джалджирийн силадууд цэргээ Бомбейн арал руу илгээжээ. Английн гарнизон Их Моголын армийн өмнө сөрөн зогсож чадсангүй. Ингээд гарнизоны командлагч 1689 онд 150 мянган рупийн төлбөр төлөх гэрээнд гарын үсэг зуржээ. Дорнод Энэтхэгийн компани португалчуудыг хөөн гаргасандаа бардамнан, бас моголуудын эзэнт гүрний хүч суларч байна хэмээн үзэж, 1685 онд Энэтхэгт байгаа эзэмшил нутгаа хүчээр тэлэн өргөтгөхийг оролджээ. Гэвч Энэтхэгийн хааны цэрэг тэдэнд сүйрлийн цохилт өгчээ.

XVII зууны 80-аад онд Энэтхэгийн далайд англичууд голлосон европын далайн дээрэмчид гарч ирэв. Аурангзеб тэднийг дээрэм хийж буй худалдаачид хэмээн бодож компаниас далайн аюулгүй байдлыг хангахыг шаардаад, 1698 онд Суратын бүх европын худалдаачдыг баривчлах тушаал өгөв. Гэвч дээрэмчдийн үйл ажиллагааг зогссонгүй учир худалдаачдыг 1704 онд дахин баривчлав. Энэ удаа Европынхан Суратаас яваа бүх Энэтхэг хөлгүүд руу довтолно гэдгийг зарлажээ. Хэрэв их хаан Аурганзеб компанихаантай ярьж тохирохгүй бол хэн ч Мекка руу мөргөлөөр явж чадахгүй хэмээн түүнд тайлбарласан учир Аурганзеб буулт хийв. Бүр Ро-гийн ед Бенегалига худалдаа хийх эрхээ авсан боловч английн анхны худалдааны суурин газар Баласард 1633 онд, дараа нь Хуглид 1651 онд байгуулагдав. Шуджи Бенегалид алба хааж байхдаа 1652 онд жилд 3 мянган рупий төлсөн нөхцөлд татваргүйгээр худалдаа хийх зөвшөөрлийг англичуудад олгожээ. Англичууд Аурганзебаас баталгаа шаардаж, татвар төлөхөөс татгалзаж байв.

Англичууд Дорнод Энэтхэгт өөрсдийнхээ үйлдвэрлэлийг байгуулахыг эрмэлзэж байжээ. Эндэхийн сангийн худалдааны суурингууд, орон нутгийн хүн амд ихээхэн өртэй болж, тэднийг моголын эрх баригчид баривчилснаар мөргөлдөөн эхлэв. Английн цэргүүд Хуглийг шатааж цөлмөөд 600 байшин, олон хөлөг онгоц, бирж өргөв. Мөргөлдөөн 1639 он хүртэл үргэлжилэв. Чарнок эргэж ирээд Калькутад худалдааны суурин үүсгэсэн нь XVII зуунд Британийн ноёрхолын төв болов. Европын улсуудаас франц ц Могол гүрний нутаг, худалдааны компани байгуулсан байв. 1639 оноос Сурата францын компаниуд болон бусад бүлэглэлийн шашин номлогчдын

төлөөлөгчид ирэв. XVIII зуунд хувийн худалдаачид ирж, Кальберийн ивээлийн дор 1664 онд л компани байгуулж дөнгөв. Хоёр жилийн дараа тэд Суратад худалдааны сууриа байгуулжээ. Мөн энэ үеэр Могол дахь Францын компани тэргүүн Ф.Кароп Шиваджиггаас худалдааны эрх авчээ. Моголын эзэнт гүрэнд бэхжиж амжаагүй «францчууд европын худалдаачдаас хамгийн түрүүнд маратхамчуудтай холбоо тогтоон зэвсэг худалдаж байв. 1670 онд Францчууд Коромандалийн эрэгт бууж 1672 онд Сан Том, 1647 онд Пондимерийг эзлэв. Францын эрх баригчид Карнатихийн нутаг дэвсгэрт санаархаж, могол, баджапур, голкондайн эвий нь олж зай чөлөө олох хэрэгтэй болов.

Оросын худалдааныхан ч Моголын эзэнт гүрэнтэй харилцахад анхаарч байжээ. Астархань хотод байсан томоохон компани их Могол гүрэнтэй худалдаа болон дипломат харилцаа тогтоох хүсэлтэй байжээ. Оросоос Их Моголын хаан Шах Жаханы орд руу хоёр удаа элч явуулсаныг (1646 онд Никита Сырожина. 1651 онд Родион Пушкинов, Иван Деревенский нарын тэргүүлсэн элч) Ираны эрх баригчид саатуулжээ. Дундад Азиар дамжуулан явуулсан Юсуф Касимовын элч нар л Их Моголын эзэнт гүрний бүрэлдэхүнд байсан Кабулд хүрсэн боловч Аурангзебтэй уулзсангүй. Эзэн хаад болон худалдаачид Орос улстай байнгын шууд холбоо тогтоохыг юу гэж үзэж байгаа хариу элч явуулах арга хэмжээ авах. Энэтхэгийн чулуучид, бусад гар урчуудыг оролцуулах зэрэг бүх захиа даалгавар дотроос Касимов зөвхөн олзлогдсон оросын хэдэн гэр бүлийнхнийг сольж авах тухай зүйлийг биелүүлсэн байна.⁽⁸⁾ Үүнээс 20 жилийн дараа Детр, Иван хаадын жуух бичигтэй оросын худалдаачин Семён Маленьский, Их Моголд ирж Аурангзеб хаанд бараалхжээ. Түүний авч ирсэн бичигт хааны болон хувийн бараагаа зарах мөн тэндээс эд бараа худалдан авах зөвшөөрөл олгохыг хүсчээ. 1696 онд Семён Маленький Аурганзебээс тус улсад худалдаа хийх зөвшөөрөл олгосон зарлигийг авч, 6 жилийн дотор сурат, Бурханпур, Агра болон бусад хотуудад очжээ. Нутагтаа буцах замдаа Иранд Маленький нас эцэслэж, түүний ачаа бараагий нь нутгийн эрх баригчид хулгайлан шамшигдуулсан ч түүнд Аурганзебээс соёрхсон түрэг хэл дээр бичсэн зөвшөөрөл зарлигийг хамт явсан нөхөд нь Москвад авч очжээ.

Монголын эзэнт гүрний түүхийн үргэлжлэл болж Чингис хааны угсааныхан Энэтхэг оронд нэгэн эзэнт гүрэн үндэслэн байгуулсан нь Их Монгол хэмээн алдаршсан байна. Тус гүрнийг үндэстэн байгуулсан Бабур хаан нь гадаад бодлогынхоо чиглэлийг Дундад Ази руу халуухан байжээ. Их Могол гүрний гадаад харилцаанд Ази, Европын олон орон нөлөөтэй байв. Их Моголын гүрэн нь Дундад зууны түүхэнд чухал үүрэг гүйцэтгэж байдаг. Тус орон нь түүхийн ихээхэн онцлог үед оршин тогтнож, Европтой харилцаа холбоогоо ихээхэн өргөжүүлсэн байв. Ялангуяа Португал, Англи, Франц зэрэг орнуудтай харилцаа, худалдааны өргөн харилцаатай байжээ. Тэд Европоос ирэгсэд, нутгийн үндсэн оршин суугчидтай зохицож, түүнийхээ үндсэн дээр хүчирхэгжиж байх оролдлого хийж байсан бололтой юм.

Эшлэл, зүүлт

1. Ж.Неру Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл. УБ. 1989, б.2, т.63
2. Мөн тэнд т.63
3. Мөн энд т.63-64
4. Бабур. Записки Бабура. Ташкент., 1958, с.304
5. Антонова К.А. Очерки общественных отношений и политического строя Могольской Индии времен Акба: а (1556-1605) М., 1989, б.2, т.68
6. Ж.Неру, Ертөнцийн түүхийг сөхвөл.. 5 .1989, б.2, т.68
7. История Индии в средние века, М., 1968, с.550 8. Мөн тэнд с.553, с.557

АЛТАН СУРГААЛИЙН
ЗОХИОГЧИЙН ТУХАЙ

А. Төмөрцэрэн

XIX зууны эцэс XX зууны эхэн үед Монгол оронд колонийн болон (феодалын дарлалыг эсэргүүцсэн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн хүчтэй өрнөж эхлэв. Үүнийг дагалдан монголын уран зохиол ардчилсан чиглэл далайцтай хөгжих боллоо. Үүний нэг жишээ нь олон түмний дунд “Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал” гэж алдаршсан шүлэглэсэн зохиол болно. Алтан сургаал зохиолыг дотоод гадаадын монголч эрдэмтэд удаа дараа судалсаар ирсэн.⁽¹⁾ Мөн 1913 оноос эхлэн дотоод гадаадад энэ зохиолыг хэвлэн нийтэлсэн нь арваад тоонд хүрч байна.⁽²⁾ Мөн гар бичмэлээр дэлхий дахины номын санд цөөнгүй байдгийг ном зүйн бүртгэлээс үзэж болно. Сүүлийн үед уг зохиолын зохиогчийн тухай асуудал анхаарал татах боллоо. Уг асуудлыг хөндөхийн тулд уг зохиолын анхны хэвлэлээс авч үзье.

Энэ зохиол 1913 онд Нийслэл хүрээнд “Ерэн хоёр шүлэгт дөрвөн бүлэгтэй шинэ зохиолын сургаал” гэсэн нэртэйгээр анх хэвлэгдсэн бололтой. Гэвч энэ анхны хэвлэл Улсын Төв номын сан болон эрдэмтэн мэргэдийн хувийн номын сангаас ухаанбаатарт олдохгүй байна. Дани улсын Копенгагены номын санд “Ерэн хоёр шүлэгт дөрвөн бүлэгтэй шинэ зохиолын сургаал” гэсэн нэртэй байдгийг Герман улсын монголч эрдэмтэн В.Хайссит “Монголын уран зохиолын түүх” хоёрдугаар ботийн 588-р талд тэмдэглэсэн байна. (Висбаден, 1972). Үүнээс гадна эрдэмтэн В.Хайссиг, Английн монголч эрдэмтэн Ч.Бауден хоёрын 1971 онд Копенгагенд хэвлүүлсэн “Монгол гар бичмэл, модон барын номын каталог” гэсэн нэр бүхий Копенгагены номын бүртгэлийн 62-63-р талд уг зохиолын нэгэн сонин хувилбар байдгийг тэмдэглэжээ. Уг зохиолын эхний нүүрэнд нь: “Зарлигаар соёрхсон буян ивээгч сүмийн гэгээний айлдсан гүнгийн зуугийн гэгээний сургаал оршив” гэж бичсэн атал зохиолын